

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 13 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлав.

ҮЭ-ИЙН ХОРООДООС ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭХ, ТӨСВӨӨ ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо нь нийслэлийн анхан шатны 19, орон нутагт 60 анхан шатны хороо харъяалагдах бөгөөд 23,5 мянган ҮЭ-ийн гишүүдээс бүрдэж байна.

1. Салбарын ҮЭ-ийн холбооны санхүүгийн хөрөнгийн эх үүсвэр нь гишүүдийн цалин буюу түүнтэй адилтгах орлогын 1 хувиар тогтоосон татвар, аж ахуйн үйл ажиллагаа явуулснаас орсон орлого, хандив, тусламж, бусад орлогоос бүрдэнэ.
2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрчний эвлэлүүд нь салбарын ҮЭ-ийн холбоондоо гишүүдээс хураасан татварынхаа 30-аас доошгүй хувийг сар бүр төвлөрүүлнэ. Аймаг суманд байршилтай салбарын анхан шатны байгууллагын ҮЭ нь салбарын ҮЭ-ийн холбоотой байгуулсан хариуцлага үр дүнгийн гэрээнд тохиролцсоноор ҮЭ-ийн татварыг төвлөрүүлнэ.
3. Мөнгөн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор дараах арга хэмжээнүүдэд зарцуулж үйл ажиллагаа явуулна. Үүнд:
 - 3.1. Хөдөлмөр нийгмийн баталгаа, эрх ашиг сонирхолоо хамтран хамгаалах тэмцэл хөдөлгөөн
 - 3.2 ҮЭ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ҮЭ-ийн эв нэгдлийг ханган ажиллах
 - 3.3 Гишүүдийн боловсрол, сургалтын ажиллагаанд
 - 3.4 Хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах, эрх зүйн өмгөөллийн туслалцаа, дэмжлэг авах
 - 3.5 ҮЭ-ийн соёл, биеийн тамирын арга хэмжээнд болон амралт сувилалд хөнгөлттэй үйлчлүүлэх
 - 3.6 ҮЭ-ийн ажилтан идэвхтэн, сонгуультан нарын цалин, шагнал, урамшуулал
 - 3.7 ҮЭ-ийн холбооны татвар
 - 3.8 ҮЭ-ийн хэвлэл, мэдээлэл, сурталчилгаа, бичиг хэргийн зардалд
 - 3.9 Хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон кампанит ажил зохион байгуулах
 - 3.10 ҮЭ-ийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд
 - 3.11 ҮЭ-ийн хяналтын хорооны үйл ажиллагаанд зориулж тодорхой хэмжээний хөрөнгө төвлөрүүлэх
 - 3.12 Салбарын хэмжээний хамтын томоохон үйл ажиллагаа явуулах зорилгоор тодорхой хэмжээний хөрөнгө төвлөрүүлэхэд
4. МҮЭ-ийн гишүүний татварыг гишүүдийн зөвшөөрсөнөөр сар бүр цалингаас бэлэн бусаар хурааж ҮЭ-ийн байгууллагын дансанд шилжүүлж байх асуудлыг хамтын гэрээгээр зохицуулна.
5. ҮЭ-ийн хороодын дарга нар жилийн эцсийн тайлан, төсвөө дараа жилийн 1 дүгээр сарын 20-ны дотор МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны санхүүд гаргаж өгч тооцоо нийлнэ.
6. Салбарын ҮЭ-ийн Холбоо болон хороодын өмч хөрөнгө, татвар, санхүүгийн үйл ажиллагаанд төр, ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч хөндлөнгөөс үл оролцоно.
7. ҮЭ-ийн өмч хөрөнгийг аливаа нэг улс төр намын болон бизнесын үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.
8. Татварын шимтгэлийг хүндэтгэн үзэх шалтгаангүй салбарын ҮЭ-ийн холбоонд төвлөрүүлэлгүй 6 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд гишүүн байгууллагын эрхийг хасах асуудлыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

9. Мөнгөн хөрөнгийг тухайн жилийн эхэнд батлагдсан төсвийн дагуу тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.
10. ҮЭ-ийн хороодын дарга нартай хариуцлага үр дүнгийн гэрээг Салбарын ҮЭ-ийн холбооны дарга хийж үр дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн тогтоол шийдвэр гаргуулж урамшуулал олгоно.
11. Сонгуульт удирдах албан тушаалтнууд ба бүх шатны сонгуультнууд, орон тооны ажилтнууд холбооны эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр эд хөрөнгийг зарах, солих, бусдад дамжуулах эрхгүй.
12. Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр үндсэн хөрөнгө худалдан авч эд хөрөнгийн бүртгэлдээ бүртгэн авах ба салбарын ҮЭ-ийн холбооны удирдлага өөрчлөгдөхөд эд хөрөнгийг зохих дансаар хүлээлцэнэ.
13. МЭХГУУ-н ҮЭ-ийн холбоо нь дүрмийн зорилтоо хэрэгжүүлэх, гишүүддээ үйлчлэх зорилгоор нийгмийн үйлчилгээний байгууллага болохын хувьд:
 - а/ Ажил хаялтын сан буюу эв санааны фонд
 - б/ Халамж даатгалын сан байгуулан ажиллаж болно.Эдгээр сан нь үйлдвэрчний эвлэлүүдийн тэмцлийн үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай тусламж үйлчилгээ авах мөн ҮЭ-ийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдана.
14. МЭХГУУ-н ҮЭ-ийн холбоо нь үндсэн нэгжийн ҮЭ-ийн хороодод санхүүгийн /сургалт, шагнал, урамшуулалт холбогдох хөнгөлөлтүүд гэх мэт/ дэмжлэг тусалцаа үзүүлж байх боловч татвар, шимтгэлээ төлсөн нөхцөлд хэрэгжүүлэх зарчим баримтлана.
15. ҮЭ-үүд хуримтлалын мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг нэмэгдүүлэх, зөв зарцуулах, ашиглалтыг сайжруулахад онцгой анхаарах үүрэгтэй.
16. ҮЭ-ийн хороо нь орон тооны болон орон тооны бус нягтлан бодогч, нярав ажиллуулна. Урамшуулалыг ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.
17. Жилд ҮЭ-ийн хороод салбарын ҮЭ-ийн холбоонд төвлөрүүлэх татварын доод хэмжээ 500000 /таван зуун мянган/ төгрөг байна.
18. ҮЭ-ийн хороодын санхүүгийн тайланд салбарын ҮЭ-ийн холбооны Хяналтын хорооноос 2 жил тутамд аудит хийж дүгнэлт гарган зөвлөн туслаж шаардлагатай тохиолдолд акт тавьж шийдвэрлүүлнэ.
19. ҮЭ-ийн гишүүдийн татварыг дараах зүйлд зарцуулахыг хориглоно. Үүнд:
 - 19.1 Төрөл бүрийн цайллага
 - 19.2 Бизнесийн үйл ажиллагаа
 - 19.3 Гадны хүнд зээл олгох
 - 19.4 Хандив өргөх /хувь хүн, гадны байгууллагад өгөх/
 - 19.5 Зээлийн баталгаа гаргах

---oOo---